



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/38

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад оруулах комисс
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд баригдсан Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Б.Энхжаргал	(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)
Гишүүд:		
	Б.Баттэмүүжин	(Боловсролын ерөнхий газрын зөвлөх)
	Т.Бат-Эрдэнэ	(Барилгын хөгжлийн төвийн ББЗХХэлтсийн хяналтын инженер)
	Г.Батхүү	(Боловсрол шинжлэх ухааны газрын хөрөнгө оруулалт гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн)
	Х.Даваасүрэн	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
	Д.Мягмарсүрэн	(Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрынБарилга техник хяналтын улсын байцаагч)
	Ж.Жавзанпагма	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
	Ж.Нацагдорж	(Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Д.Сүхээ	(Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)
	Б.Аюуш	(“Хөвсгөл эрчим хүч”ХХК-ийн Ашиглалтын албаны дарга
Зураг төслийн байгууллагын төлөөлөл:		
	М.Төртогт	(“Рино констракшн” ХХК-ийн инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
М.Төмөрбаатар ("Б-Софт" ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Б.Цэрэн-Очир (Цагааннуур сумын Засаг дарга)
М.Санжаа (Цагааннуур сумын сургуулийн захирал)

Комиссын нарийн бичгийн дарга:
Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)


2. Барилга байгууламжийг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) - д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН